



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 526

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан
байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой
эрсдэлийн удирдлагын журам боловсруулах
үлгэрчилсэн заавар”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн
6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин
зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг
хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан
байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам
боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг үндэслэн өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон
ажиллахыг банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба
(Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800001099



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 526

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг үндэслэн өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГМИЙН ХҮЧИН ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ
БОЛОВСРУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР**

Энэхүү зааврын зорилго нь Банк бус санхүүгийн байгууллага зээл олгохдоо зээлдэгчийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө, болзошгүй эрсдэлийг цогц, системтэй байдлаар тодорхойлох, үнэлэх, удирдах мөн байгаль орчны холбогдох стандарт, шаардлагыг зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэхийг тогтооход заавар болгон ашиглахад оршино.

ББСБ нь өөрийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тогтвортой санхүүжилт болон байгаль орчин нийгэм засаглалын талаар авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг тусгахыг эрмэлзэнэ.

ББСБ нь байгаль орчны хэтийн төлөвт эрсдэл учруулж болзошгүй салбарт үйл ажиллагаа явуулж буй аливаа байгууллагыг санхүүжүүлэх тохиолдолд магадлан үнэлгээг хэрэгжүүлж болно.

ББСБ нь зээлийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг мөрдөж ажиллах журмыг байгууллагын стратеги, зорилт, тогтвортой байдлын бодлоготой уялдуулж холбогдох хууль тогтоомж, журам, заавар, олон улсын стандарт, болон энэхүү зааврыг удирдлага болгож байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зээлдэгчид дэлгэрэнгүй зааварчилгаа өгөх, ББСБ-ын зээл, санхүүжилт олгох үйл ажиллагааны мөчлөгийн үе шатанд авах арга хэмжээ зэргийг харгалзан өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам нь:

1. Нийтлэг үндэслэл
2. Баримтлах зарчим
3. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явц
4. Талуудын эрх үүрэг
5. Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

Энэхүү зааврын үндсэн 5 бүлэгт байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой онцлогийг харгалзан журамд зайлшгүй байх асуудлыг ерөнхийлөн тусгасан.

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГМИЙН ХҮЧИН ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ЖУРМЫН БҮТЭЦ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйл ажиллагаанд мөрдөх журмын зорилгыг эрх бүхий байгууллагаас баталж гаргасан заавар, бодлого, журмуудтай уялдуулан зээлдэгчийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө, болзошгүй эрсдэлийг цогц, системтэй байдлаар тодорхойлох, үнэлэх, удирдах мөн байгаль орчны холбогдох стандарт, шаардлагыг зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэхийг тогтооход байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой хяналтын хуудас, эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл, мониторинг хяналт шалгалт, тайлангийн загвар, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн асуудалд хамаарах үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, стандартууд, холбогдох олон улсын конвенц, хэлэлцээр, хоригууд гэх мэт бусад холбогдох баримт бичгүүдийн хамт эрсдэлийн удирдлагыг зохицуулахад чиглүүлэх.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Банк бус санхүүгийн байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчим (Хавсралт 1); хамтран санхүүжилт хийх тохиолдолд түнш байгууллагуудын баримтлах Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой бусад бодлого, журам (тухайлбал, Экваторын зарчим, Дэлхийн банкны бүлгийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж)-ыг баримтална.

2.2. Харилцагчийн бизнесийн үйл ажиллагаа нь байгаль орчин, хүн ам, төсөл хэрэгжих байршлын ойр орчмын ард иргэд, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байх үүднээс ББСБ нь Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт (Хавсралт 2)-ыг баталж мөрдөх. Энэхүү жагсаалтад заасан аливаа бизнесийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл эсвэл тухайн ББСБ эсвэл түүний хувьцаа эзэмшигчдийн зүгээс баримталж буй бусад асуудлуудын улмаас санхүүжүүлэхгүй байх зарчим баримтална.

Гурав. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явц

3.1. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох анхан шатны үнэлгээ

3.1.1. ББСБ нь харилцагчийн үйл ажиллагаа эрхлэх салбарын ангилалд үндэслэн эрсдэлийн анхан шатны үнэлгээ хийнэ.

3.1.2. Харилцагчийн үйл ажиллагаа эрхлэх салбар нь санхүүжүүлэхийг хориглосон жагсаалтад байвал, санхүүжилт олгох боломжгүй талаар харилцагчид мэдэгдэнэ. Санхүүжилт авахаар төлөвлөж буй төсөл нь Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад ороогүй тохиолдолд төслийн анхан шатны эрсдэлийн түвшинг төслийн үйл ажиллагааны салбарын ангилал болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлагатай үйл ажиллагааны жагсаалтад (Хавсралт 3) орсон эсэхийг үнэлнэ.

3.1.3. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх эсэх нь төслийн эрсдэлийн шинж чанар, үйл ажиллагаа явуулах салбар болон цар хүрээ, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшин зэргээс шалтгаална.

3.1.4. Санхүүжилт авахаар төлөвлөж буй үйл ажиллагаа, төслийг үйл ажиллагаа явуулах салбарын ангиллаар нь Их, Дунд, Бага эрсдэлтэй эсвэл А, В, С ангилал гэж ангилна.

3.1.4.1. Эрсдэл багатай төсөл нь нарийвчилсан үнэлгээ хийлгэхгүйгээр дараагийн үе шат руу шилжих боломжтой;

3.1.4.2. Дунд болон өндөр эрсдэлтэй төслүүдэд нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай болно.

3.2.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

3.2.1.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ Санхүүжилт авахаар төлөвлөж буй үйл ажиллагаа, төсөл нь Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад ороогүй тохиолдолд ББСБ-ын зүгээс байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг зээлийн судалгааны нэг хэсэг болгон хийх (шаардлагатай бол) болно гэдгийг тухайн боломжит зээлдэгчид мэдэгдэнэ. Ингэснээр тухайн санхүүжүүлэх төсөл эсвэл харилцагчийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг илрүүлэн тодорхойлж ББСБ-ын зүгээс болзошгүй эрсдэлийг удирдах боломжтой болно.

3.2.2.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний хэрэгсэлд тулгуурлан тухайн харилцагч болон санхүүжилт хийгдэх төслийн түвшинд хийнэ.

3.2.3.Санхүүжилт хүссэн төслөөс хамааран байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ нь дор дурдсан нэг буюу хэд хэдэн аргачлалуудыг агуулна. Үүнд:

3.2.3.1.баримт бичгийн хяналт;

3.2.3.1.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон менежментийн төлөвлөгөө;

3.2.3.1.2.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, онцгой байдлын журам;

3.2.3.1.3.хүний нөөцийн бодлого;

3.2.3.1.4.байгаль орчны холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл болон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бусад зөвшөөрөл, бичиг баримтууд;

3.2.3.1.5.тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой бусад холбогдох бичиг баримтууд.

3.2.3.2.цахим мэдээллийн эх сурвалж ашиглан хайлт хийх;

3.2.3.4.зохицуулалтын хууль дүрэмтэй нийцтэй байдлыг хянах;

3.2.3.5.зээлдэгчийн төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлыг удирдах боломж, хариуцлага чадавхыг үнэлэх;

3.2.3.6.тухайн зээлдэгчийн төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг удирдах боломж, хариуцлага, чадавхыг үнэлэх;

3.2.3.7.шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалт хийх (Хавсралт 4: Газар дээрх шалгалтын удирдамж);

3.2.3.8.өндөр эрсдэлтэй төсөлд бүрэн хэмжээний техникийн хяналт, үнэлгээ хийх.

3.3.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал

3.3.1.Харилцагчийн төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн эцсийн үнэлгээг дараах байдлаар өгнө. Үүнд:

Төслийн эрсдэл	Харилцагч/зээлдэгч/компанийн эрсдэл		
	Өндөр	Дунд	Бага
Өндөр (А ангилал)	Өндөр	Өндөр	Дунд
Дунд (В ангилал)	Өндөр	Дунд	Бага
Бага (С ангилал)	Дунд	Бага	Бага

3.3.2.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшинг (жишээлбэл, Өндөр, Дунд эсвэл Бага) тухайн харилцагч/зээлдэгч/компанид олгох зээлийн ерөнхий үнэлгээний үр дүнд оруулан нэгтгэдэг.

3.4.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах болон шийдвэр гаргах үйл ажиллагаа

3.4.1.Зээлийн мэргэжилтэн Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг боловсруулж, Зээлийн хороонд хүргүүлэх;

3.4.2.Зээлийн хороо нь тухайн төслийн нийт үр өгөөж, болзошгүй эрсдэлийг үнэлж зээл олгох эсэх эцсийн шийдвэрийг гаргахдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийн асуудлыг харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэлийг бууруулах шаардлагыг батална;

3.4.3.Өндөр эрсдэлтэй төслийн хувьд зээл олгох шийдвэрийг шийдвэр гаргах дээд шатны албан тушаалтнууд (жишээлбэл, ТУЗ-ийн хороо) гаргана;

3.4.4.Тодорхой нөхцөлтэйгөөр санхүүжилт олгохыг зөвшөөрсөн тохиолдолд зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд (Зээлийн гэрээнд тусгах байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой заалтуудын жишээг Хавсралт 5) байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой заалтуудыг тусгана. Уг заалтуудад засаж залруулах арга хэмжээ эсвэл үнэлгээний явцад илэрсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлдэгч нь Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх шаардлагыг багтаана. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны журам, зорилтууд, хүлээгдэж буй гүйцэтгэлийн хугацаа, тайлагнах шаардлага зэргийг нарийвчлан тусгана. (Засаж сайруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар Хавсралт 6).

3.5.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хяналт ба дотоод тайлагнах үйл явц

3.5.1.Санхүүжилт олгохоор зөвшөөрөгдсөн төслүүдийн хувьд хийгдэх мониторинг хяналтын үйл ажиллагааг зээлийн баримт бичигт заасны дагуу тодорхой давтамжтайгаар хийнэ.

3.5.2.Зээлийн эрсдэлийн удирдлагын тогтмол хийгдэх үйл ажиллагааны нэг хэсэг болгон байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянаж болох ба хяналтын цар хүрээ нь зээлдэгчийн төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшингээс хамаарна.

3.5.3.Зээлийн болон Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний мэргэжилтний зүгээс зээлийн ашиглалтын нийт хугацаанд зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, тухайн асуудалтай холбоотой шаардлагатай дотоод тайлан, мэдээллийг шаардаж болно (Харилцагчийн үйл ажиллагаанд тавих мониторинг, хяналтын загвар - Хавсралт 7).

3.5.4.Хэрэв зээлдэгч нь зээлийн гэрээнд тусгагдсан байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зохих арга хэмжээ авах ба зээлийн гэрээнд тусгагдсан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.5.ББСБ-ын зүгээс өөрийн зээлийн багц дахь байгаль орчин, нийгмийн болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн түвшинг тодорхойлохын тулд тодорхой салбаруудыг сонгон тогтмол хугацаанд хяналт, үнэлгээ хийнэ.

3.5.6.ББСБ-ын _____ [хариуцсан нэгж/ажилтан, жишээлбэл, Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний газар, хэлтэс/мэргэжилтэн] нь тогтмол (жишээлбэл жилд нэг удаа) хугацаанд Гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ (Хавсралт 8).

3.6.Бичиг баримтын бүртгэл болон хадгалалт

3.6.1.Дараах бичиг баримт, бүртгэлийг хадгална. Үүнд:

3.6.1.1.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үр дүн болон Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний тайлан;

3.6.1.2.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн Засаж сайжруулах шаардлага болон зээлийн гэрээнд тусгасан холбогдох зүйл заалтууд;

3.6.1.3.газар дээрх шалгалтын тайлан болон хяналт тавьж буй төслүүдийн байгаль орчин, нийгмийн асуудалд мониторинг, хяналт тавьсан талаарх бичиг баримт, бүртгэл;

3.6.1.4.зээлдэгчийн зүгээс бэлтгэсэн тайлан, мэдээлэл баримт бичиг;

3.6.1.5.холбогдох бусад баримт бичиг болон тайлангууд.

Дөрөв. Талуудын эрх үүрэг

4.1.Харилцагчтай ажиллах зээл олгох алба нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.1.1.газар дээрх шалгалт, шаардлагатай баримт бичгийг цуглуулах, Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг бэлтгэх замаар эрсдэлийг тодорхойлох анхан шатны үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээ хийх;

4.1.2.санхүүжилт хийгдсэн төсөл бүрийн хувьд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг зохих журмын дагуу хийж, үнэлгээтэй холбоотой бичиг баримт, бүртгэлийг хадгалах;

4.1.3.зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой асуудал болон түүнийг бууруулах арга хэмжээний талаар хэлэлцэн тохиролцох;

4.1.4.холбогдох бүх гэрээ бичиг баримтад байгаль орчинтой холбоотой зохих төлөөлөл, баталгаа, зүйл заалтуудыг тусгах;

4.1.5.байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой зээлдэгчийн гаргаж буй ахиц дэвшил, өөрчлөлтийг хянах.

4.2.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний мэргэжилтэн/нэгж нь дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.2.1.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэн, энэ талаар Харилцагчтай ажиллах зээл олгох албанд зөвлөгөө өгөх;

4.2.2.зээл олгох шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг болох байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулахтай холбоотой шаардлагатай арга хэмжээний талаар санал зөвлөмж өгөх;

4.2.3.зээлийн хороонд санхүүжилт хүссэн тухайн төслийг санхүүжүүлэх эсэх талаар өөрийн санал зөвлөмжийг өгөх;

4.2.4.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилттэй холбоотойгоор Харилцагчтай ажиллах зээл олгох алба болон Зээлийн эрсдэлийн удирдлагын нэгжтэй хамтран ажиллах;

4.2.5.зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг үнэлэх болон хянахад Зээлийн мэргэжилтэн болон Зээл/Хөрөнгө оруулалтын шинжээчдэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

4.2.6.ББСБ-ын зээлийн багцын түвшин дэх байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх;

4.2.7.байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой аливаа ноцтой асуудлыг ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад тайлагнаж, дотоод болон гадаад оролцогч талуудад жил бүр тайлагнах үйл ажиллагааг хариуцах;

4.2.8.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны нэг хэсэг болох холбогдох журам, баримт бичгийг боловсруулж, шинэчлэх;

4.2.9.харилцагчтай ажиллах зээл олгох алба болон зээл олгох үйл ажиллагаанд шууд оролцдог ББСБ-ын бусад ажилтнуудад зориулан байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой мэдээлэл, танилцуулга хийх, сургах, чадавхыг бэхжүүлэх.

4.3. Зээлийн хороо нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотойгоор

зээл олгох шийдвэр гаргахдаа төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үр дүн болон холбогдох байгаль орчны эрсдэл, үр дүнг харгалзан шийдвэр/дүгнэлт гаргана.

4.4. Гүйцэтгэх удирдлага нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.4.1.ББСБ-аас харилцагч, ханган нийлүүлэгчдэд тавигдах байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой шаардлага, нөхцөлийг тодорхойлсон Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журмыг батлах;

4.4.2.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилтэд хяналт тавих;

4.4.3.зээлийн багцын түвшний байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянах;

4.4.4.компанийн стратеги төлөвлөгөөний дагуу байгаль орчин, нийгмийн эрсдэлийн талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулах.

4.5.Хуулийн хэлтэс нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.5.1.ББСБ-аас тавьж буй байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой шаардлагыг санхүүжилт олгож буй бүх холбогдох төслүүдийн зээлийн гэрээнд тусгах;

4.5.2.зээлдэгч нь зээлийн гэрээнд тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой зүйл заалтуудыг дагаж мөрдөөгүй нь гэрээг зөрчсөн болон гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдол гэж үзэх эсэхэд санал зөвлөмж гаргах.

4.6. Комплайнсын газар нь байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой холбогдох шаардлага, шалгуурууд нь Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам болон холбогдох хавсралтуудад тусгагдсан эсэхийг байнга хянана.

4.7. Аудитын газар нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.7.1.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилтийг хянаж ТУЗ-д тайлагнах;

4.7.2.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилт, хяналт хангалттай байгаа эсэхийг баталгаажуулж, хэрэв хэрэгжилт, хяналт тохиромжгүй бол сайжруулалтыг санал болгох;

4.7.3.байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний холбогдох аргачлал, арга ажиллагааг хянаж, шаардлагатай бол сайжруулах саналуудыг дэвшүүлэх.

4.8.Хүний нөөцийн хэлтэс нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой дараах үндсэн үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

4.8.1.байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг тусган ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх;

4.8.2.байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой сургалт, семинарыг зохион байгуулах.

Тав. Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

5.1.Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийх, шийдвэр гаргах, хяналт тавих үйл явцад оролцдог холбогдох нэгж/ажилтнуудыг сургах ажлыг ББСБ-ын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний нэгж Хүний нөөцийн хэлтэстэй хамтран зохион байгуулна.

5.2.ББСБ-д шинээр ажилд орж буй Зээлийн мэргэжилтнүүдэд зориулсан холбогдох сургалтуудад байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагатай холбоотой сургалтын модулиудыг агуулсан байх.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн нэгдүгээр хавсралт

Монгол Улсын тогтвортой санхүүгийн зарчмууд

Монгол Улсын тогтвортой хөгжлийн асуудлуудад анхаарлаа хандуулж, банк бус санхүүгийн байгууллагуудад Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогын идэвхтэй оролцогч байхад нь туслах зорилгоор Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчмуудыг боловсруулсан болно. Энэ нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, бий болохоос зайлсхийхийг эрмэлзэх, түүнчлэн улс орны ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилгод нийцсэн төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах Тогтвортой санхүүгийн тогтолцоог бий болгох нэг арга зам юм.

Зарчим 1: Байгаль орчноо хамгаалах

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

Зарчим 2: Хүний эрх, нийгмийг хамгаалах

Бид хүний эрх, хөдөлмөрийн стандартыг хүндэтгэж, дэмжин, сурталчлах ба иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, тэдгээрийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

Зарчим 3: Соёлын өвийг хамгаалах

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн нийгэм, соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

Зарчим 4: “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Зарчим 5: Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Бид эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн хүмүүст очих санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, харилцагчийг хамгаалах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Бид хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

Зарчим 7: Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны тогтвортой санхүүжилтийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

Зарчим 8: Манлайлан үлгэрлэх

Бид Монгол Улсад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эерэг хөгжлийг авчрахад шинэлэг санаачилга гарган, идэвхтэй ажиллана. Бид өөрсдийн үлгэрлэн манлайллаараа харилцагчид болон салбартаа ижил жишиг тогтоохыг эрмэлзэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн хоёрдугаар хавсралт

Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт

Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг олон улсын холбогдох сайн туршлага болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг харгалзан боловсруулсан болно. Энэхүү жагсаалтад Монгол Улсад төдийлөн санхүүжүүлдэггүй зарим үйл ажиллагааг агуулсан байж болох боловч энэ жагсаалт нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллагуудын зүгээс санхүүжилт авах боломжууд гарч ирвэл тэдгээрт тохирсон байхаар хийгдсэнтэй холбоотой юм.

Монгол Улсын санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх ББСБ-ууд дараах үйл ажиллагаануудыг санхүүжүүлэхээс татгалзана. Үүнд:

1. Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсаас даалгасан олон улсын хууль тогтоомж, конвенц, хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагаа;

2. Сэтгэцэд нөлөөлөх ургамал тариалах, хуульд заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдаалах;

3. Зохисгүй буюу хууль бус мөрийтэй тоглоом, казиногийн бизнес;

4. Садар самуун сурталчилсан үйлдлийг маркетинг, дэмжих, зохион байгуулах;

5. Албадан хөдөлмөрийн хор хөнөөлтэй, мөлжлөгийн хэлбэр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, ялгаварлан гадуурхалт, ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр хийх эрхийг хуульд заасан аливаа үйл ажиллагаа;

6. Буу, дайны зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;

7. Олон түвшний маркетинг, пирамид схемээр ашиг олох;

8. Холбогдох улс орнуудын зохих зөвшөөрөл, зөвшөөрөлгүйгээр экспортлох, импортлох, улс орон даяар худалдаа хийх;

9. Олон улсын болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт байрлах үйл ажиллагаа;

10. Биологийн олон янз байдал, түүх, соёлын өвийг хамгаалах тухай олон улсын конвенц, хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагаа;

11. Асбест болон түүнийг агуулсан аливаа бүтээгдэхүүнд үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт;

12. ПХБ-Полихлорт бифенил агуулсан аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа;

13. Олон улсад хориглосон озон задлах бодис агуулсан бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;

14. Олон улсын хэмжээнд хориглосон эм, шахмал, шавьж устгах бодис болон бусад хортой бодис үйлдвэрлэх, худалдаалах;

15. CITES-ээс хориглосон зэрлэг амьтан, ургамлын сорьцын худалдаа;

16. Тогтворгүй загас агнуурын аргууд (жишээлбэл, тэсэлгээний загас агнуур)

17.Олон улсад хориглосон хаягдал материалыг тээвэрлэх, устгах;

18.Хамгаалалтын өндөр ач холбогдолтой ойн бүс нутагт мод бэлтгэх (жишээлбэл, Хангайн ой) болон тусгай хамгаалалттай газартай холбоотой ойн болон мод бэлтгэлийн тоног төхөөрөмжийн худалдаа;

19.Тогтвортой менежменттэй ойгоос гараагүй мод бэлтгэх, мод, ойн бүтээгдэхүүний худалдаа;

20.Роттердамын конвенц болон Стокгольмын конвенцид заасны дагуу хасагдсан болон хориглосон зүйл.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн гуравдугаар хавсралт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлагатай үйл ажиллагааны жагсаалт

Төслийн ангилал	Хариуцах эрх бүхий байгууллага	
	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар
1. Уул уурхайн төслүүд	- Бүх төрлийн ашигт малтмал олборлох	- Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр олборлох
2. Хүнд аж үйлдвэрийн төслүүд	- Эрдэс боловсруулах (баяжуулах) - Боловсруулах - Химийн үйлдвэр - Кокс-химийн үйлдвэр - бусад бүх төрөл	
3. Хөнгөн болон хүнсний үйлдвэрийн төслүүд	Улсын хэмжээний том үйлдвэр	Орон нутгийн жижиг болон дунд бизнесүүд
4. Хөдөө аж ахуйн төслүүд	- Усан сан - Усалгааны систем - Газар эзэмшүүлэх үйл ажиллагаа	- Орон нутгийн ойжуулалтын төсөл - Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн - Тариалалт
5. Дэд бүтцийн хөгжлийн төслүүд	- 1МВт-аас дээш хүчин чадалтай цахилгаан станц - 35 кВ-оос дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - Халаалтын хоолой - Усан цахилгаан станц - Төмөр зам - Нисэх онгоцны буудал - Улс дамнасан замын сүлжээ - Хот хоорондын харилцаа холбоо - Газрын тосны бүтээгдэхүүний агуулах	- 1МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц - 35 кВ хүртэлх цахилгаан дамжуулах шугам - Нутаг дэвсгэр доторх дулаан дамжуулах шугам - Орон нутгийн зам, харилцаа холбооны дэд бүтэц - Шатахуун түгээх станцууд
6. Үйлчилгээний салбарын төслүүд	- 50-иас дээш ортой зочид буудал, амралтын газар болон бусад үйлчилгээний газрууд	- 50 хүртэлх ортой зочид буудал, амралтын газар болон бусад үйлчилгээ - Аялал, аялал жуулчлал

<p>7. Бусад төслүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хотын хөгжил - Батлан хамгаалах, иргэний хамгаалалтын зориулалтаар хэрэгжүүлэх төслүүд - Усан хангамжийн систем - Ус цэвэршүүлэх байгууламж - Хатуу хог хаягдлын төв 	<ul style="list-style-type: none"> - 10000 гаруй хүн амтай төв, суурин газрын ус хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын цэгүүд. 	<ul style="list-style-type: none"> - 10000-аас доош хүн амтай төв, суурин газрын ус хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын цэг - Батлан хамгаалах, иргэний хамгаалалтын орон нутгийн чанартай байгууламж
<p>8. Биологийн олон янз байдалтай холбоотой төслүүд</p>	<ul style="list-style-type: none"> - Улсын хэмжээний томоохон загас агнуур - Ан амьтан, ургамал шилжүүлэх (нутагшуулах) 	<ul style="list-style-type: none"> - Ан агнуур, ойн аж ахуй, ан агнуурын бааз - Нутгийн хүн амын хэрэгцээг хангах загасны аж ахуй
<p>9. Генийн өөрчлөлттэй холбоотой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Генийн өөрчлөлттэй хувиргасан амьд организм гарган авах - Генийн өөрчлөлттэй хувиргасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл - Генийн өөрчлөлттэй хувиргасан амьд организмын тариалалт - Генийн өөрчлөлттэй хувиргасан бүтээгдэхүүнийг импортлох - Генийн өөрчлөлттэй хувиргасан бүтээгдэхүүний тээвэрлэлт, худалдаа 	<ul style="list-style-type: none"> - Генийн өөрчлөлттэй хувиргасан амьд организмын тариалалт - Генийн өөрчлөлттэй хувиргасан амьд организмыг ашиглан жижиг, дунд үйлдвэр эрхлэх - Ойжуулах, нөхөн сэргээх зэрэгт генийн өөрчлөлттэй хувиргасан амьд организмыг ашиглах
<p>10. Химийн хорт болон цацраг идэвхт бодис, аюултай хог хаягдлын төсөл</p>	<ul style="list-style-type: none"> - химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдлыг боловсруулах, ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах 	
<p>11. Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах төсөл</p>	<ul style="list-style-type: none"> - улсын тусгай хамгаалалттай газар, хилийн боомтод хийгдэх үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хийгдэх үйл ажиллагаа

Энэхүү жагсаалтыг 2012 оны Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар баталсан болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн дөрөвдүгээр хавсралт

Газар дээрх шалгалтын удирдамж

Газар дээрх шалгалтын удирдамж	
А. Ерөнхий мэдээлэл	
Зорилго	ББСБ-ын холбогдох ажилтан нь санхүүжилт хүссэн зээл, төслийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагааны хүрээнд болон зээл олгосны дараах хяналт, мониторингийн явцад газар дээр нь очиж шалгах боломжтой. Газар дээрх шалгалтын гол зорилго нь хэрвээ анхаарахгүй орхивол харилцагч/зээлдэгч/компанийн бизнесийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэх мөн ББСБ-аас тавьж буй байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шаардлагад харилцагч/зээлдэгч/ компанийн үйл ажиллагаа хэрхэн нийцэж байгааг шалгахад чиглэгддэг.
Бэлтгэл ажил	<p>Газар дээрх шалгалтыг хийхээс өмнө ББСБ-ын холбогдох ажилтан нь дараах зүйлүүдийг бэлтгэх хэрэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн үйл ажиллагааны ерөнхий тодорхойлолт, хөдөлмөрийн практик, ойр орчмын газар ашиглалтын талаарх тойм, холбогдох мэдээллийг судлах - Хаана ямар байршилд очихыг тодорхойлох - Харилцагч/зээлдэгч/компанийн зүгээс байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой урьдчилсан мэдээлэл авах хүсэлт гаргах. Жишээлбэл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо зэрэг мэдээллийг бэлтгэхийг хүсэх - Тухайн төслийн үйл ажиллагаа явуулж буй салбарт түгээмэл тохиолддог байгаль орчин, нийгмийн эрсдэлийн асуудлуудын талаар ерөнхий ойлголтыг бий болгохын тулд холбогдох мэдээлэл болон салбарын удирдамжийг (жишээлбэл, Дэлхийн банкны бүлэг/ОУСК-ын Салбарын удирдамж болон Салбарын мэдээлэл) судлах - Харилцагч/зээлдэгч/компанийн зүгээс уулзах гол хүмүүс болон асуух гол асуултуудыг тодорхойлон бэлтгэх - Газар дээр ажиллах хөтөлбөрийг бэлтгэх (төслийн үйл ажиллагаа явагдаж буй байршил, газартай танилцах, гол хүмүүстэй ярилцахад хангалттай цаг гаргах) - Хэрэв ББСБ-тай өмнө нь хамтран ажиллаж байсан харилцагч бол өмнө нь авсан зээлийн гүйцэтгэлийг шалгах - Харилцагч/зээлдэгч/компани эсвэл төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ямар нэг асуудал өмнө нь үүсэж байсан эсэхийг цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан хайх, судлах
Газар дээр хийгдэх ажиллагаа	<p>Газар дээрх шалгалтыг явуулах хэд хэдэн аргачлалыг доор харууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Харилцагч/зээлдэгч/компанийн байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой үйл ажиллагааг ажиглахын тулд тухайн байршил, газрыг тойрон алхаж, зураг авах

	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтнууд, хүний нөөцийн ажилтнууд, техникийн ажилтнууд зэрэг төслийн үйл ажиллагаанд шууд оролцож буй холбогдох ажилтнудаас зорилтот асуултуудыг асуух - Холбогдох баримт бичгүүдийг судлах, шалгах (жишээлбэл, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, тайлан гэх мэт).
--	--

В. Газар дээрх шалгалтын үеэр судлах, анхаарах байгаль орчин, нийгмийн гол асуудлууд

Энэ хэсэгт төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар дээр очиход нийтлэг харагддаг байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой асуудлууд болон энэ тохиолдолд ашиглаж болох сайн туршилагын талаар тайлбарласан болно. Энэхүү заавар нь зөвхөн ерөнхий жишээ бөгөөд бүрэн гүйцэд эсвэл техникийн дэлгэрэнгүй зааварчилгаа, мэдээлэл биш гэдгийг анхаарна уу.

Асуудал	Ямар зүйлийг анхаарах хэрэгтэй вэ?	Т/Ү	Тайлбар
1. Гол бичиг баримтуудтай танилцах, шалгах			
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын аудитын тайлан, Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө (хэрэв боломжтой бол)		
	Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн бодлого/Журам		
	Онцгой байдлын төлөвлөгөө		
	Хүний нөөцийн бодлого		
	Эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох зөвшөөрлийн гэрчилгээ, баримт бичгүүд		
2. Байгаль орчны асуудал			
Агаарын бохирдол	Жишээлбэл, агаарт ялгаруулах хийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүүгээр ялгаруулж байгаа эсэхийг шалгах		
Усны бохирдол	Жишээлбэл, ус гоожсон/асгарсан байдал харагдаагүй; төслийн үйл ажиллагаа нь усны урсгал, ундаргатай ойр байгаа эсэхийг шалгах; усны урцын хэмжээ зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн байдал харагдаагүй.		
Газар, хөрсний бохирдол	Жишээлбэл, агуулах, хадгалах савны эргэн тойронд гоожиж, асгарсан шинж тэмдэг илрээгүй; бохирдолд хүргэж болзошгүй газар ашиглалтын ямар нэг шинж тэмдэг байхгүй; хөрс рүү шингэн гоожихоос хамгаалах шаардлагатай тоног төхөөрөмжтэй.		
Хог хаягдлын удирдлага	Жишээлбэл, хог хаягдлын менежментийн зохих төлөвлөгөө/гэрээтэй; хог хаягдлыг хадгалах зохих байгууламжтай; аюултай хог хаягдлыг зохих ёсоор устгадаг/хадгалдаг байх.		

Биологийн олон янз төрөл зүйл	Жишээлбэл, тухайн газар нутагт төсөл нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй; ан амьтадын амьдрах орчныг хамгаалсан/сэргээсэн; төсөл нь тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулаагүй байх.		
Уур амьсгалын өөрчлөлт	Жишээлбэл, тухайн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн үер, ган гачиг, цаг агаарын бусад хүнд үзэгдлүүд бий болж байсан түүх байхгүй.		
2. Эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой асуудлууд			
Хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлага	Жишээлбэл, Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэшсэн ажилтнуудыг томилсон; хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг бэлтгэсэн; хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтын төлөвлөгөө, тайланг баримтжуулсан; мониторинг хяналтын үйл ажиллагаа хийгддэг байх.		
<i>Үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламжийн загвар болон үйл ажиллагаа</i>			
Орох гарах/ Зай талбай	Жишээлбэл, төслийн үйл ажиллагааг аюулгүй явуулахад хангалттай ажлын байр, зай талбайтай байх; яаралтай тусламжийн хүртээмжтэй орц, гарцтай байх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан шаардлагатай төхөөрөмж, байгууламжтай байх (жишээлбэл, тэргэнцэрт зориулсан налуу зам); талбай дээрх тэмдэг тэмдэглэгээ тод харагдаж байх.		
Ерөнхий аюулгүй байдал	Жишээлбэл, төслийн үйл ажиллагаа явуулах байршил, талбай нь цэвэр, эмх цэгцтэй, хөдөлгөөнд аюул учруулахгүй байх; явган хүний замыг ямар нэг саад тотгоргүй байлгах; тоног төхөөрөмжийн байдал, нөхцөл боломжийн харагдаж байх; анхны тусламжийн холбогдох хэрэгсэлтэй байх.		
Галын аюулгүй байдал	Жишээлбэл, гал асахад хүргэх түлш, хүчилтөрөгчийн бүх эх үүсвэрийг тодорхойлсон байх; шатамхай материалыг зохих ёсоор хадгалах; гал унтраах хэрэгсэлтэй байх; онцгой байдлын/гал түймэртэй тэмцэх журамтай байх.		
<i>Ажилчдад учирч болзошгүй биет эрсдэлүүд (Гэмтэл болон аюулгүй байдлын эрсдэлүүд)</i>			
Өндрөөс унах	Жишээлбэл, шат бэхлэгдсэн байх; өндрөөс унахаас урьдчилан сэргийлэх хамгаалалтын хашлага суурилуулсан байх; ажилчид хамгаалалтын бүс зүүсэн байх; тоног төхөөрөмжийг байнга шалгадаг байх; ажилчдад хяналт тавьдаг байх.		
Цахилгааны аюулгүй	Жишээлбэл, цахилгаан тоног төхөөрөмжийн ойролцоо ажилладаг ажилтнуудад зориулсан сургалт, мэдээллийг		

байдал	өгдөг байх; цахилгаан самбар / дамжуулагч түгжигдсэн байх (зөвхөн эрх бүхий ажилтнуудад хандах боломжтой); цахилгаан кабель утаснууд хамгаалалттай байх.		
Замын тээврийн аюулгүй байдал	Жишээлбэл, жолооч нар холбогдох сургалтад хамрагдаж, жолооны үнэмлэхтэй байх; жолоо барих үед гар утас ашигладаггүй байх; согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгахын тулд өдөр бүр шалгалт хийдэг байх.		
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Жишээлбэл, замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөтэй байх; тээврийн хэрэгслийн болон явган хүний замыг тусгаарласан байх; тээврийн хэрэгслийн салхины шил/гэрэл зөв ажиллаж байгаа эсэхийг шалгадаг байх; ажилчид гэрэл цацруулагчтай тод өнгийн хүрэм, хувцас өмсдөг байх.		
Газар шорооны ажлыг явуулахтай холбоотой аюулгүй байдал	Жишээлбэл, тулгуур, шат, хамгаалалтын бэхэлгээ, хамгаалалтын хашлага зэрэг аюулгүй байдлыг хангах зүйлүүдтэй байх; ажилчид шаардлагатай сургалтад хамрагдсан байх; хяналт шалгалтыг ээлж бүрийн эхэнд хийдэг байх.		
<i>Эрүүл мэндэд учрах эрсдэлүүд</i>			
Биет	Жишээлбэл, өвчний бүртгэлтэй байх; хангалттай гэрэлтүүлэгтэй байх; ажлын орчин цэвэр байх; давчуу нөхцөл байдалд ажиллахгүй байх; ажлын байр нь хангалттай халаалт/хөргөлтийн системтэй байх; ажилчдыг тохирсон хувцсаар хангах; ажлын байранд ямар нэг хурц үнэр байхгүй байх.		
Химийн	Жишээлбэл, аюултай бодисыг аюулгүй хадгалах, ашиглах, тээвэрлэх, устгах; материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудастай байх; зөв тоног төхөөрөмжийг ашигладаг байх.		
Цацраг туяаны	Жишээлбэл, цацраг туяаг зөвхөн зориулалтын талбайд ашигладаг байх; холбогдох тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан байх; цацрагийн ашиглалтыг эрх бүхий ажилтнууд хянадаг байх.		
<i>Ажил эрхлэх үйл ажиллагаа</i>			
Ажлын байрны нөхцөл	Жишээлбэл, ажлын цаг, завсарлага, амралтын цаг нь орон нутгийн дүрэм журамд нийцсэн байх; ажилчдын байрлах байр (төсөл хэрэгжиж буй газар дээрх) цэвэр, тохиромжтой чанартай байх (усан хангамж, дулаан, дуу		

	чимээ, галын хамгаалалт гэх мэт).		
Хүүхдийн/а лбадан хөдөлмөр	Жишээлбэл, төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар дээр нь хууль ёсны хөдөлмөрийн насанд хүрээгүй ажилчид байгаа эсэхийг шалгах; ажилчид цалингаа авч байгаа бөгөөд ямар нэг өр төлөх байдлаар ажиллахгүй байгаа гэдгийг баталгаажуулах.		
Бусад			
3. Нийгмийн асуудлууд			
Аюулгүй байдал	Жишээлбэл, хурц үнэр, их хэмжээний дуу чимээ, тоосжилт байхгүй байх; асгарах, гоожих болон бусад тохиолдлыг шалгах; үйл ажиллагаа нь гал/дэлбэрэлт/өвчин үүсгэж болзошгүй эсэхийг шалгах; тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; холбогдох зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан байх.		
Газар ашиглалт	Жишээлбэл, газрын ашиглалтыг өөрчилсөн тухай нотлох ямар нэг нотолгоо байхгүй; албадан нүүлгэн шилжүүлэлт/эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой орон нутгийн иргэдийн гомдол байхгүй байх; холбогдох зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан байх.		
Цөөнхийн бүлгүүд	Жишээлбэл, цөөнхийн бүлгийг ялгаварлан гадуурхсан талаарх ямар нэг нотлох баримт байхгүй байх; холбогдох зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан байх.		
Соёлын өв	Жишээлбэл, төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нь ямар нэг соёлын өв (биет болон биет бус) болон болзошгүй эрсдэлтэй ойр байгаа эсэхийг шалгах.		
Хүйсийн тэгш байдал	Жишээлбэл, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тэгш бус байдлаар хандсан тухай нотлох баримт байхгүй байх (тэгш бус цалин, ажилчдын тэтгэмж).		
Бусад			

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн тавдугаар хавсралт

Зээлийн гэрээнд тусгах байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой заалтуудын жишээ

Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой шаардлагатай заалтуудыг боловсруулж, зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тусгахад ББСБ-ын Хуулийн хэлтэс оролцох хэрэгтэй. Үүнтэй холбоотойгоор зээлийн гэрээнд тусгах нөхцөл, тусгай үг хэллэг нь тухайн зээл, санхүүжилтийн төрөл, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний явцад илэрсэн эрсдэлийн хүчин зүйлээс хамаарах боловч ерөнхийдөө дараах асуудлуудыг хөндөж авч үздэг. Үүнд:

1. Эерэг утгатай зүйл заалт, нөхцөлүүд: Эдгээр нь харилцагч компанийн зүгээс авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээтэй холбоотой амлалт юм. Заасан зүйл заалтуудыг (эерэг ба сөрөг зүйл заалт, нөхцөлүүд) ноцтойгоор зөрчих нь ихэвчлэн зээлийн гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй гэж тооцох тохиолдол болдог.

Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотойгоор зээлийн гэрээнд зээлдэгч компанийн зүгээс биелүүлэх дараах эерэг утгатай зүйл заалт, үүрэг, амлалтуудыг оруулж болно. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой улсын хэмжээнд даган мөрдөгддөг бүх хууль, дүрэм, стандартыг биелүүлэх, дагаж мөрдөх;
- ББСБ-ын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шаардлагыг хангах, биелүүлэх;
- Шаардлагатай бүх зөвшөөрлийг авч, дагаж мөрдөх;
- Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үйл ажиллагааны төлөвлөгөөг ихэвчлэн зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээний хавсралт болгон оруулдаг. Төлөвлөгөөнд харилцан тохиролцсон цаг хугацаанд зээлдэгчийн зүгээс авч хэрэгжүүлэх засаж сайжруулах тодорхой арга хэмжээнүүдийг тусгадаг.
- Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага, стандартад нийцсэн Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх/үйл ажиллагаандаа ашиглах;
- Холбогдох гэрчилгээ, стандартын зарчим, шалгуурыг дагаж мөрдөх (жишээлбэл, ISO 14001, OHSAS 18001);
- Агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр ажиллах;
- Хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Газрын элэгдэл, эвдрэлээс урьдчилан сэргийлэх;
- Эрүүл ахуй, аюулгүй байдлын зохих арга хэмжээг дагаж мөрдөх;
- Бие махбод, сэтгэл санаа, бэлгийн дарамтаас ангид, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн орчин нөхцөлөөр хангах;
- Холбогдох хөдөлмөрийн хууль, тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллах;

- Холбогдох хөдөлмөрийн хууль, тогтоомжийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлөх;

- Төсөл болон харилцагч компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой биет болон биет бус соёлын өвд ямар нэг ноцтой сүйрэл, гэмтэл гарахгүй байхыг анхаарч ажиллах (Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчим, удирдамжийн дагуу);

- Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой хууль тогтоомж, зөвшөөрлийг зөрчсөн, зээлдэгч компанийн эсрэг байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой гомдол, нэхэмжлэл гарсан, байгаль орчин, нийгэмд нөлөөлөх томоохон осол, гэмтэл гарсан (хүний амь эрсдэх, ноцтой гэмтэл учрах эсвэл их хэмжээний бохирдолд хүргэсэн ус, химийн бодис шингэн, хорт хий ялгарах асгарах, ажлын байрны осол гэх мэт) тохиолдолд ББСБ-д цаг тухайд нь яаралтай мэдэгдэх (жишээлбэл, 3 хоногийн дотор);

- ББСБ-д Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаарх тайланг ББСБ-ын шаардлага хангасан хэлбэрээр тогтмол гаргаж өгөх (Байгаль орчин, нийгмийн мониторингийн тайлан);

- Зээлийн гэрээнд заасан байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой холбогдох зүйл заалт, нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах зорилгоор ББСБ болон түүний төлөөлөгчдөд зээлдэгч компанийн үйл ажиллагаа эрхэлдэг газарт болон холбогдох бүртгэл, тайлантай танилцах зөвшөөрөл олгох (ажлын цагаар болон [...] хоногийн өмнө энэ талаар урьдчилан мэдэгдэх).

2. Сөрөг утгатай зүйл заалт, нөхцөлүүд: Үүнд зээлдэгч компанийн зүгээс хийхээс татгалзах ёстой үйлдлүүд орно.

Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотойгоор зээлийн гэрээнд зээлдэгч компанийн зүгээс анхаарах дараах сөрөг утгатай зүйл заалт, үүрэг, амлалтуудыг оруулж болно. Үүнд:

- ББСБ-ын Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад орсон аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх

- Санхүүгийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжтэй ямар нэг бизнесийн харилцаанд орохгүй байх.

3. Урьдчилсан нөхцөл: ББСБ-аас зээл, санхүүжилт олгохоос өмнө харилцагч компанийн биелүүлэх ёстой нөхцөл, шаардлага орно. Үүнд:

- Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүчинтэй зөвшөөрөл, лицензийг авсан байх, үүнийг нотлох баримт;

- Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой бүх шаардлагатай лиценз, зөвшөөрлүүдийг авсан болохыг баталгаажуулсан бие даасан, хараат бус Байгаль орчин, нийгмийн/Хуулийн зөвлөхийн дүгнэлт;

- Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж дууссан байх;

- Байгаль орчин, нийгмийн /Эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтныг томилсон байх.

4. Гэрээг зөрчсөн тохиолдол, үйл явдал: Энэ нь ББСБ-ын зүгээс харилцагч/зээлдэгч/компанид олгосон санхүүжилтийг цуцалж, олгосон зээл, санхүүжилтийг нэн даруй буцаан төлөх ёстой гэж зарлахад хүргэх үйл явдал, тохиолдол гарахыг хэлнэ. Байгаль орчин, нийгэмтэй холбоотой нарийн төвөгтэй асуудлыг агуулсан төслийн хувьд ББСБ-д энэ үйл явдал гарсан гэж мэдэгдсэнээс хойш зээлдэгч компанийн зүгээс асуудлыг шийдвэрлэхэд 30 хоногийн хугацаа өгч болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн зургаадугаар хавсралт

Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

/Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний хэрэгслийг үзнэ үү/

Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг ихэвчлэн зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээний хавсралт болгон оруулдаг. Төлөвлөгөөнд харилцан тохиролцсон цаг хугацаанд зээлдэгчийн зүгээс авч хэрэгжүүлэх засаж сайжруулах тодорхой арга хэмжээнүүдийг тусгадаг.

Байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой анхаарах асуудлууд	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах зардал	Гол үзүүлэлт/ тайлагналын шаардлага	Хэрэгжилтийн байдал
<i>Жишээлбэл, Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо</i>	<i>Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлж хэрэгжүүлэх</i>	<i>Гүйцэтгэх удирдлага / Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний мэргэжил тэн Гадны зөвлөх</i>	<i>Эхний санхүүжилт олгохоос өмнө</i>	<i>Гадны зөвлөх авч ажиллуулах зардлыг тооцоолох</i>	<i>Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсруулан баталсан ББСБ-д Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн жилийн тайланг хургуулэх</i>	

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн долоодугаар хавсралт

Харилцагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, мониторинг хийх загвар

Энэхүү загварын дагуу зээл, санхүүжилт олгосны дараа зээлийн ашиглалтын хугацааны турш зээлдэгч компанийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд мониторинг хийж, хяналт тавих боломжтой. Үүнд, **Байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой болзошгүй эрсдэлийн нөлөөллийг бууруулахтай холбоотой Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон/эсвэл зээлийн гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих ажиллагаа орно.**

Харилцагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, мониторинг хийх загвар						
1. Ерөнхий мэдээлэл						
Харилцагч/зээлдэгч/компанийн нэр			Бэлтгэсэн:			
Зээл/санхүүжилтийн хэмжээ, төрөл			Ажилтны нэр болон албан тушаал			
Зээл/санхүүжилтийн зориулалт			Цахим шуудангийн хаяг			
Үйл ажиллагааны салбар			Огноо			
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал	A/B/C					
2. Мониторинг, хяналт хийх үе дэх ерөнхий төлөв байдал						
Мониторингийн хугацаа						
Төслийн хэрэгжилтийн байдал						
Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой гэрээгээр хүлээсэн үүрэг, шаардлагуудын биелэлт, хэрэгжилт	<input type="checkbox"/> Хангалттай <input type="checkbox"/> Дунд зэргийн хангалттай <input type="checkbox"/> Хангалтгүй					
Засаж сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
3. Мониторинг, хяналтын үйл ажиллагааны үр дүн						
Байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой анхаарах асуудлууд	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гол үзүүлэлт/ тайлагналын шаардлага	Хэрэгжилтийн байдал	ББСБ-д гаргаж өгсөн бичиг баримт	Газар дээрх шалгалтын тэмдэглэл

<i>Жишээлбэл , Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо</i>	<i>Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлж хэрэгжүүлэх</i>	<i>Эхний санхүүжилт олгохоос өмнө</i>	<i>Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсруулан баталсан ББСБ-д Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн жилийн тайланг хүргүүлэх</i>				

4. Шаардлагатай засаж сайжруулах арга хэмжээний хураангуй болон мониторинг, хяналтын үед илэрсэн байгаль орчин, нийгмийн асуудлууд (хэрэв байгаа бол)

Байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй холбоотой анхаарах асуудлууд	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гол үзүүлэлт/ тайлагналын шаардлага	Тэмдэглэл/тайлбар

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 526 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ийн наймдугаар хавсралт

ББСБ-ын зээлийн багцын түвшний дотоод гүйцэтгэлийн тайлан

Энэхүү тайланг ББСБ-ын гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох нэгжид тодорхой хугацааны давтамжтайгаар (жишээлбэл, сар, улирал) бэлтгэж танилцуулна.

Ерөнхий мэдээлэл		
Тайлангийн хамрах хугацаа	Хэднээс:	Хэдэн хүртэл:
Тайланг бэлтгэсэн	(Нэр албан тушаал)	(Огноо)
Тайланг хянаж баталсан	(Нэр албан тушаал)	(Огноо)
Тайланд ашигласан валютын нэр		

Хэсэг 1: Хэсэг 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо	
1.1 Тайлангийн хугацаанд Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн бодлого/журамд ямар нэгэн өөрчлөлт орсон уу?	<input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм, тайлбарлана уу?
1.2 ББСБ-ын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны бодлого/үйл ажиллагаатай холбоотой томоохон асуудал/гомдол гарсан уу?	<input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тийм, тайлбарлана уу?

Хэсэг 2: Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох анхан шатны үнэлгээ болон эрсдэлийн үнэлгээ					
2.1 Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний ерөнхий үр дүн					
Үйл ажиллагааны салбар	Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг ... дээш үнийн дүнтэй зээл, санхүүжилт дээр хийсэн				
	Зээл,	Нийт	Бага эрсдэлтэй	Дунд эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй

	санхүү- жилтийн үнийн дүн	зээл, санхүү- жилтийн тоо	Дүн	Тоо	%	Дүн	Тоо	%	Value	#	%
.....											
Нийт дүн											
ББСБ-ын нийт зээл, санхүүжилтийн тоо											
ББСБ-ын нийт зээл, санхүүжилтийн үнийн дүн											
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу үнэлгээ хийгдсэн нийт зээл, санхүүжилтийн тоо											
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу үнэлгээ хийгдсэн нийт зээл, санхүүжилтийн үнийн дүн											
ББСБ-ын нийт зээл, санхүүжилтийн үнийн дүнд Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу үнэлгээ хийгдсэн нийт зээл, санхүүжилтийн үнийн дүнгийн эзлэх хувь											
2.2 Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ											
2.2.1 Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой Засаж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарсан зээл, санхүүжилт / Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой мониторинг хийгдэж буй зээл, санхүүжилт											
Но	Харилцагч/Төсөл	Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал (А/В/С)	Нийт хэмжээ/үнийн дүн			Нийцтэй байдлын хэрэгжилтийн байдал (Хангалттай / Дунд зэргийн хангалттай / Хангалтгүй)					
1											
2											
...											
Ерөнхий дүр зураг						Үнийн дүн	Тоо	%/Үнийн дүн	%/Тоо		

Шаардлагыг Хангалттай хангасан зээл, санхүүжилт				
Шаардлагыг Дунд зэргийн хангалттай хангасан зээл, санхүүжилт				
Шаардлагыг Хангалтгүй хангасан зээл, санхүүжилт				
2.2.2 Санхүүжүүлэхээс татгалзсан зээл, санхүүжилт, тайлбар (жишээлбэл, Санхүүжүүлэхийг хориглосон жагсаалтад багтсан, хүүхдийн/албадан хөдөлмөр эрхлэлт байсныг нотлох баримт байгаа, гэх мэт)				
Но	Харилцагч/Төсөл	Үйл ажиллагааны салбар	Хүссэн санхүүжилтийн хэмжээ	Тайлбар
2.2.3 Тайлант хугацаанд гарсан байгаль орчин, нийгмийн ноцтой эрсдэлтэй төслүү/харилцагчид				
Но	Харилцагч/Төсөл	Байгаль орчин, нийгмийн эрсдэл	Байгаль орчин, нийгмийн асуудлыг удирдах зорилгоор авсан арга хэмжээ	

Хэсэг 3: Бусад (боломжтой бол нэмэлт санал/зөвлөмж оруулна уу)

--